

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрэнноров	Дугаар	L220
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Хашаат сум
Төрсөн газар	Хашаат сум	Төрсөн он	1936
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Их номгоны хийд	Сүм хийдийн дугаар	АРХШ 064
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Архангай аймгийн Хашаат сумын Номгоны хийд

Сүмтийн уулын өвөр бэлд байх Номгоны хийдийн түүрин дээр байна. Энэ газар орчим бол УБ-аас Хархорины чиглэлийн төв замаас урагшаа 3 орчим км газар, мөн УБ-аас Арвай хээрийн чиглэлийн төв замаас хойшоогоо 2 орчим км газар. Энэ бүс нутагт энэ Сүмтийн уулын өвөр бэл дээх энэ түүрин дээрээс зүүн урагшаа Их Монгол уул 20 гаруй, 30 шахам км-т харагдаж байна. Мөн баруун урагшаа Их Эрээний нуруу 20 орчим км-т харагдаж байна. Ийм түүхийн дурсгалт газруудын бүс нутагт багтдаг ийм хийд байна. Энэ хийд нь академич Ренчин гуайн жагсаалтанд ороогүй бид Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Булган аймгийн Гурванбулаг сумд байх жагсаалтаас хайж үзсэн. Шинээр илэрсэн хуучны хийдийн түүрин дээр байна. Та энэ хийдийн дэргэд өсөж төрсөн хүний хувьд энэ хийдийн талаар ярьж өгнө үү?

Цэрэнноров:

За энэ бол Жамсран шүтээнтэй, сахиус нь. Хэдэн дуган байсан, 200 орчим лам байсан юм байгаа байхаа. Энэ сүм чинь Дарь эхийн сүм гээд ярьдаг юм, зарим нь Номгоны сүм л гэдгийн. Гэхдээ энэ Дарь Эхийн сүмээрээ л байх. Дарь Эх багш л гэдэг байсан юм даа хийдийн ламыг нь. Энэ чинь Архангайд яваад л биш болсон юм гэнэ

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

лээ, баригдаад явчихсан юм гэнэ лээ. Ирээгүй юм гэдэг. Би бол 2,3 настай байхад л ингээд айхтар юм болсон юм байна лээ. Миний мэдэж байгаа нэг зуун нас байна, тэрний урд талд нэг зуун нас байх байх гэж бодож байна. Миний л бодол.

Мөнхбат:

Жас хөрөнгө гэж юмтай байсан юм болов уу?

Цэрэнноров:

Байсан юм гэнэ лээ. Гайгүй овоо юм байсан. Овоо л юм байсан гэдэг. Зарим нь ирээд мөнгө санга ухаад л явсан гэдэг юм байна лээ. Манай хөгшчүүл ухах нь битгий хэл гар хүрч болохгүй гээд ойртохын аргагүй байсан.

Мөнхбат:

Төвд номын дурсгалтай Өөр шашны дурсгалууд байсан уу?

Цэрэнноров: Байсан. Энэ овоо нь дээр бидний сууж байгаа овоон дээр нэг их том дөрвөлжин хүрэн хадан дээр зөндөө ном бичсэн байсан, бодвол маани л байх. Одоо энд тал эмтэрхий нь байна. Ямар үсэг нь юм. Энэ дээр нэг айл нутаглаад л байсан.

Мөнхбат:

Хэдэн суврага байсан бэ?

Цэрэнноров:

Тэр зүүн хойно нэг байсан, энэ хойно нэг байсан би бол буурийг нь үзсэн шүү дээ. Эхлээд сайхан амьдарч байх үед нь би төрөөгүй л байсан байна шүү.

Мөнхбат: Одоо энэ малын өвөөлжөө энэ тэрээ бариад айлын эзэмшилд орсон байна тиймээ, хэдийнээс ингэсэн бэ?

Цэрэнноров:

Нэгдэл эхлүүт л энд чулуун хороо барисан юм, бригадын хүчээр. Чулуун хороо бариад л ганц хоёр айл буугаад л байсан чинь одоо ингээд өвөлжөө болжээ, ойрын жил үзээгүй. Зөндөө наадах чинь сайхан юм байсан юм.

Мөнхбат:

За мэдээлэл өгсөн танд баярлалаа.